



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/620

Ховд

Ховд аймгийн тооллогын комиссын
бүрэлдэхүүнийг томилох тухай

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “з” заалт, Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 315 дугаар тогтоол, Аж ахуйн нэгжийн ээлжит тооллогын улсын комиссын 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аж ахуйн нэгжийн 2021 оны ээлжит тооллогыг зохион байгуулж явуулах аймаг, сумын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Аймгийн түвшинд:

Комиссын дарга: Т.Жаргалсайхан - Аймгийн Засаг даргын орлогч

Орлогч дарга: Л.Ариунаа - Аймгийн статистикийн хэлтсийн дарга

Гишүүд Б.Ганболд - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Ч.Багдал - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Х.Батцэцэг - Татварын хэлтсийн дарга

С.Хоролсүрэн - Улсын бүртгэлийн газрын дарга

Х.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Б.Бямбажав - Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Ц.Мягмарсүрэн - Эрүүл мэндийн газрын дарга

Б.Алтангэрэл - Боловсролын газрын дарга
Н.Батчулуун - Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
Н.Ирэхзаяа - Авто тээврийн үндэсний төвийн газрын дарга
Б.Даваасүрэн - Цагдаагийн газрын дарга
Л.Билэгдэмбэрэл - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
Д.Батцэнгэл - Мал эмнэлэгийн газрын дарга
Ц.Цогтбаяр - Жаргалант сумын Засаг дарга
Х.Алтантуяа - Хэвлэл мэдээллийн ажилтан

Нарийн бичгийн

дарга: Х.Мөнхзолбоо - Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Сумын түвшинд:

Комиссын дарга Сумын засаг дарга эсвэл Засаг даргынорлогч
Гишүүд: Тамгын газрын дарга
Санхүү, төрийн сангийн албаны дарга
Татварын ажилтан
Улсын бүртгэгч
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогохариуцсан ажилтан
Хөдөө аж ахуйн ажилтан
Боловсрол, шинжлэх ухаан, соёлын асуудал хариуцсан ажилтан
Сургууль, соёлын төвийн захирал
Багийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Статистик хариуцсан ажилтан /санхүү төрийн сангийн мэргэжилтэн/

2. Аймгийн комиссоос өгсөн нэгдсэн удирдамж, заавар, чиглэлийн дагуу тооллогыг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, тоологч нарын халдвар, хамгаалал, аюулгүй байдлыг хангаж ажиллах, аж ахуйн нэгжийн ээлжит тооллогын ажилд хяналт тавин, дүн мэдээг нэгтгэж, тооллогын үйл ажиллагааг явуулсан тайлан, илтгэх хуудсыг бэлтгэн аймгийн комисст 2021 оны 12 дугаар сарын 05-ны дотор хүлээлгэн өгөхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ